



ХЭНТИЙ АЙМАГ  
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 124

Бэрх

Ажлын хэсэг  
томилох тухай

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 02/129 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус хотын тэтгэвэр авагч иргэдийн тэтгэврийн хувийн хэргийг тоолох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: ЗАА-ны дарга

Гишүүд:

Нийгмийн даатгалын улсын байцаагч

Татварын улсын байцаагч

Хүнс, хөдөө аж ахуйн мэргэжилтэн

Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан

2. Тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг хуулийн хүрээнд чанартай зохион байгуулж, заасан хугацаанд Хэнтий аймгийн нийгмийн даатгалын газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн орлогч (Н.Бахыт)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ



Ч.ЭНХЖАВХЛАН

232501024